



**БАТЛАВ:**

БОАЖЯ-ны ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ .....  **Ч.БАТСАНСАР**



---

**“МОНГОЛИАН ПЕТРОЛИУМ ИНЖЕНЕРИНГ” ХХК-ИЙН  
ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ХИМИЙН БОДИС  
ИМПОРТЛОХ, ХАДГАЛАХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ”  
ТӨСЛИЙН  
БАЙГАЛЬ, ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ  
(2021-2025 ОН)**

---

**Боловруулсан:**

“Риск энвайрон” ХХК-ийн Гүйцэтгэх  
захирал, доктор



**Д.ЭНХТАЙВАН**

**Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:**

“Монголиан Петролиум Инженеринг” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал



**Б.МАРГАД-ЭРДЭНЭ**

Улаанбаатар хот  
2021 он

**ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ  
“ХИМИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХАДГАЛАХ, ХУДАЛДАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Боловсруулсан: Д.Ганцолмон**

**2023 он**

**Байгаль хамгаалах зардалд жилд 52,600,000 сая төгрөг зарцуулна.**

**Үүнээс :**

- **хог хаягдалд 46,500,000 сая.төг,**
- **Орчны хяналт шинжилгээнд 566.0 мян.төг орсон байгаа.**
- **Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, зардал 5,534,000**

## **1.Төслийн товч танилцуулга**

*Төслийн нэр:* “Химийн бодис импортлох, хадгалах, худалдах”

*Төслийн байршил:* Дорнод аймгийн Матад сумын Буян-Өндөр буюу 4-р багийн нутагт “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ний 19-р талбайд байрлалтай.

*Төслийн зорилго:* Төсөл хэрэгжүүлэгч нь Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй газрын тос олборлох “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн захиалгаар газрын тосны хайгуулын өрөмдлөгийн явцад шаардлагатай химийн бодис, бүтээгдэхүүнийг Хятад улсаас импортлон тээвэрлэж хадгалах, туслан гүйцэтгэгч Өрмийн III ангид нийлүүлэх, худалдах зорилготой.

*Ашиглах технологи:* “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн туслан гүйцэтгэх Өрмийн 3-р ангийн өрөмдлөг хийх явцад бэхжүүлэгч болгон ашигладаг.

*Үйлдвэрлэх бүтээгдэхүүн /төрөл/:* 42 нэр төрлийн химийн бодис импортлон агуулахад хадгалж худалдан нийлүүлнэ. Өөрөөр хэлбэл төсөл хэрэгжүүлэгч компани нь БОАЖЯ-наас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу анх 2017 онд 10 нэр тэрлийн химийн бодис, бүтээгдэхүүн нийлүүлж байсан бол 2021 онд 42 төрлийн химийн бодис бүтээгдэхүүн импортлох, хил дамжуулан тээвэрлэх, хадгалах, худалдах тусгай зөвшөөрлийг тус тус авсан байна.

*Үндсэн түүхий эд, туслах материал, түүний хангамж:* Химийн бодис

*Ашиглах технологи:* “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн туслан гүйцэтгэх Өрмийн 3-р ангийн өрөмдлөг хийх явцад бэхжүүлэгч болгон ашигладаг. Эдгээр химийн бодис нь цооногийн ус алдалтыг бууруулагч, зуурамтгай чанарыг багасгагч буюу шингэрүүлэгч, шавар ба шаварлаг чулуулгийн хатуу, шингэн фазын шүтлэг орчинг тохируулагч, үрэлтийг бууруулах тослогч нэмэлтүүд зэрэг цооногийн шингэний физик, химийн шинж чанарыг тогтворжуулах, дээшлүүлэх, цооногийн ашиглах хугацааг уртасгах зорилготой органик нийлмэл полимерт нэгдлүүд болон органик бус давс зэрэг химийн бодис бөгөөд эдгээр бодисууд нь Монгол улсын нутаг дэвсгэрт хэрэглэхийг хориглосон болон хязгаарласан бодисын тоонд ороогүй болно.

*Төслийн хүчин чадал /сар, жил/:* Жил бүрийн 5-р сараас 10 сар хүртэлх хугацаанд дунджаар 2000-3000 тн химийн бодис импортлодог. 2019 онд 2326.5 тн бодис импортлосон.

*Борлуулах зах зээл /гадаад, дотоод/:* “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн Өрмийн 3-р ангид нийлүүлж ашиглана.

*Түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэх шийдэл:* БНХАУ-ын Өвдөг боомтоос Баянхошуу боомтоор дамжуулан хатуу хучилттай замаар тусгай тоноглогдсон хүнд даацын 4-5 автомашинаар тээвэрлэнэ.

## **2.Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт**

Төсөл хэрэгжих нутаг Монгол орны физик-газарзүйн мужлалтаар Монголын Дорнод талын их мужийн Дорнодын тэгш талын мужид хамрагдах Тамсагийн талын тойрогт багтана. Энэ тойрог нь үлдэц нам уул, ухаа гүвээ, хотос хонхор багатай тэгш гадаргадээ. Өбдөөдээ, үйд Мэнэнгийн тэгш тал, Зүрхийн цагаан хоолой, Тамсаг булгийн хоолой зэрэг нуур-пролювийн болон нуур-аллювийн

хурдаст тал, Буйр нуурын өмнөд хэсгийн дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх элэгдлийн тэгш, долгиорхог гадарга хамрагдана. Гадарга нь  $10^0$  далайн түвшнээс дээш 620-720 метрийн өндөр  $10^0$  налуу нь 10 м/км-ээс хэтэрдэггүй. Тус талбайд  $10^0$  баяа урсгал усны үйл ажиллагаа  $10^0$ ,  $10^0$   $10^0$   $10^0$   $10^0$   $10^0$   $10^0$   $10^0$   $10^0$  хөндий зүүн хойшоо буюу Буйр нуур луу чиглэж  $10^0$  сурвасхан, хотос байдалтайгаар оршино. Төсөл хэрэгжих талбай нь  $10^0$  хэвгий бүхий тэгш гадаргатай, далайн түвшнээс дээш 645 метр өндөрт оршино.

Уур амьсгалын мужлалтаар хуурай сэрүүвтэр зун, хахирдуу өвлийн мужид хамрагдана. Энэ нутаг нь нам уул, ухаа гүвээт болон талархаг тэгш гадаргатай уур амьсгалын хэлбэлзэл багатай, арай зөөлөвтөр бөгөөд өвлийн үргэлжлэх хугацаа богино байна.

Төсөл хэрэгжих орчинд гадаргын ус байхгүй. Уг нутаг нь гидрогеологийн мужлалтаар Дорнод Монголын гидрогеологийн районд хамрагдах бөгөөд энэ нь Номхон далайн ай савын эхний хэсэг болдог. Иймд төсөл хэрэгжих районд ихэнх тохиолдолд нүх сүв, нүх сүв-давхаргын газар доор ус бүрэлдэн тогтсон байдаг.

Хөрсөн бүрхэвчийн хувьд нунтаг карбонатлаг хүрэн хөрс голлон тархсан бөгөөд нугын марзлаг мараат хөрс энд тэнд толбо байдлаар тархжээ.

Ургамал бүрхэвчийн хувьд Монгол дорнод хэв шинжид хамаарагдах Харгана бүхий жижиг бутлаг үетэн- хиаг-хялганат, хиаг, чулуусаг алаг өвс-ботуульт бүлгэмдэлтэй хосолсон чулуусаг алаг өвс-хялганат бүлгэмдэл тархана.

“Монголиан Петролиум Инженеринг” ХХК-ийн импортлон тээвэрлэж буй химийн бодис, бүтээгдэхүүнийг хүлээн авах “Петро Чайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн агуулахуудын байршил нь Улаанбаатар хотоос 860 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос 223 км, Матад сумын төвөөс 80 км зайтай оршино. Матад сум нийт 851 өрхийн 3226 хүн амтай. Сумын өрхийн 268 нь сумын төвд, 576 малчин өрх хөдөөд мал аж ахуй эрхлэн амьдардаг. Нийт 164910 толгой малтай, үүнээс адуу 29240, үхэр 22070, тэмээ 550, хонь 67950, ямаа 45150 байна. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр сумын төсвийн орлогыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, шинээр 5-8 ажлын байр бий болгох, түүнчлэн ажлын байраар хангагдсан хүмүүс болон тэдний гэр бүлийн хүмүүсийн амьжиргааны түвшин дээшлэх зэрэг нийгэм, эдийн засагт үзүүлэх сайн талууд нэлээд байна.

### **3. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт**

“Монголиан Петролиум Инженеринг” ХХК-ийн химийн бодис импортлон тээвэрлэх, хадгалах, худалдах үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрс, ургамал, гүний ус зэрэг байгалийн голлох хам бүрдлүүд болон ажиллагсдын эрүүл мэндэд учирч болзошгүй нөлөөллийг дараах байдлаар авч үзвэл:

#### **Төслийн гол болон сөрөг нөлөөлөл:**

##### **1. Хөрсөн бүрхэвчид**

- Төслийн хүрээнд ашиглагдах химийн бодис, бүтээгдэхүүнийг тээвэрлэн хүргэх үйлчилгээний явцад машин, техникийн хөл хөдөлгөөний улмаас урт хугацаандаа агуулах орчмын хөрсний үржил шимт өнгөн хэсэг талхагдаж халцрах, элэгдэл эвдрэлд өртөх, физик химийн шинж чанарт өөрчлөлт орох улмаар устаж болзошгүй
- Химийн бодисыг ил задгай байрлуулснаас бороо, үерийн усны нөлөөгөөр орчин бохирдох
- Химийн бодисыг ил задгай хаях, асгах, шатах тослох материалын асгаралтаас хөрс бохирдох

##### **2. Усан орчинд**

- Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд байнгын урсгалт гол, горхи, булаг шанд байхгүй тул төслийн үйл ажиллагаанаас гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөө

байхгүй гэж болно. Усан хангамжийн байгалийн нөөц чанарт үзүүлэх нөлөө бага, урт хугацааны туршид тодорхой цэгт, бүрэн нөхөн сэргээгдэнэ.

- Төслийн хэмжээнд хэрэглэгдэх химийн бодисуудыг тээвэрлэх, хадгалах, ачиж буулгах явцад хөрсөнд асгаснаас газрын доорхи усны чанарт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

### 3. Ургамлан нөмрөг, амьтанд

- Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, сав баглаа боодлын битүүмжлэл, устгалын цикл үйл ажиллагааны зохих заавар, журмыг зөрчин хайхрамжгүй байдлаас орчны хөрс, ургамал бохирдон түүгээр дамжин мал, амьтан шууд бусаар хордох
- Төслийн үйл ажиллагааны явцад тухайн бүс нутгийн амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бараг байхгүй байх боловч амьтдын идэш тэжээлээ эрж хайх, усанд гүйх, нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийдэг коридор нутгаар дамжин тээвэрлэлт хийж магадгүй байгаа тул хөхтөн амьтад, ялангуяа цагаан зээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөнд урт хугацаандаа бага зэрэг сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Хортой бодисоор хордсон ургамал идсэнээр мал, амьтан хордох

### 4. Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

- Химийн бодис, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, ачиж буулгах үеийн аюулгүй ажиллагааны дүрэм журам, зааврыг баримтлан ажиллаагүйн улмаас асгаж, алдсан тохиолдолд ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж арьс, нүд, хамар хоолойг цочроох, хурц болон ужиг архаг хордлого үүсгэх, амьсгалын замын эрхтний системийг гэмтээх, улмаар хавдар үүсгэх зэргээр ихэнхдээ богино хугацаанд ажиллагсдын эрүүл мэндэд шууд нөлөөлөх нөлөөллийн эрчмийг нэмэгдүүлж болзошгүй.

### 5. Газрын гадарга, хотгор гүдгэрийн хэв шинж, геологийн тогтоцод үүсэж

болзошгүй сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагааны хүрээнд ямарваа нэгэн эрдэс баялаг ашиглах болон геологийн тогтоц, геоморфологийн төрх байдлыг өөрчлөх үйл ажиллагаа явагдахгүй тул тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага боловч урт хугацаандаа машин техникийн хөл хөдөлгөөний улмаас агуулах орчмын гадарга бага зэрэг өөрчлөгдөж болзошгүй. Тухайлбал машины замаар жижиг шан, ховил үүсч тэдгээр нь тур зуурын урсгал усны нөлөөгөөр эвдрэн хотгор гүдгэрийн сийлээ хэлбэрийг бий болгох эрсдэлтэй. Ингэснээр тэгш гадарга бартаажна.

## **4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт**

Төсөл хэрэгжүүлэгч нь “Химийн бодис тээвэрлэх, хадгалах, худалдах” төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарах гол болон болзошгүй бүх сөрөг нөлөөллөөс төсөл хэрэгжих нутгийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд энэхүү байгаль орчны менежментийн үндсэн зорилго оршино.





	хөрс бохирдох	гаргаж байх					
4	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, сав баглаа боодлын битүүмжлэл, устгалын цикл үйл ажиллагааны зохих заавар, журмыг зөрчин хайхрамжгүй байдлаас орчны хөрс, ургамал бохирдон түүгээр дамжин мал, амьтан шууд бусаар хордох	Химийн бодисын сав, баглаа боодлын битүүмжлэлийг сайтар шалгах, урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах, ажилчдад байнга анхааруулга, санамж өгч хэвших					
НИЙТ							

#### 6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж, тоо хэмжээ	Нэгжийн болон нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агуулах орчмын хөрсний элэгдэл, эвдрэлийг багасгах	Агуулахын үүд орчмыг хатуу хучилттай болгох	3 агуулахын үүд орчим	100м <sup>2</sup>	1,600,000	2023	
2	Агуулах болон хогийн цэг орчмыг ургамалжуулах	Агуулах болон хогийн цэг орчимд нутгийн унаган ургамал болох бут, сөөг, хиаг, хялгана үрээр тарих, арчилах	Агуулахын эргэн тойрон	100м <sup>2</sup>	2,400,000		
НИЙТ					5,000,000		



**7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Төсөл хэрэгжих нутагт түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газар байхгүй болно.

**8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө**

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Давтамж	Тоо хэмжээ, нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгаж хийх боломжтой зориулалтын сав авч, ялган таних тэмдэг тавьж, байрлуулах	Ажилчдын болон машин техникийн гаралтай хог хаядал (хатуу, шингэн)	кг/л	2	46,196,000	2023	
		Хог хаягдлыг тогтмол тээвэрлэн зайлуулах арга хэмжээ авч байх	Ажилчдын хэрэглээнээс гарах хатуу хог хаягдал	кг				
2	Аюултай	Химийн бодисын үлдэгдэл, сав, баглаа боодол, картон хайрцаг зэргийг тусгайлан хадгалж гэрээт компанид өгч устгал хийлгэх	Химийн бодис хадгалах агуулах, түүний ойр орчим	Ширхэг	2			
НИЙТ						46,196,000		

**9.Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Хөрсөн бүрхэвчид эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Агуулах болон хогийн цэгийн ойр орчимд	5,8-р саруудад					
2	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Гүний худгийн ус	Ажиллах хугацаанд буюу 8-р сард сард					
3	Ундны усны иж бүрэн шинжилгээ			1	50.0	50.0		
4	Ундны усан дахь хүнд металлын агууламж		7 сард	1 удаа	180.0	180.0		
НИЙТ					565.0	565.0		

**10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
1	Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх осол эрсдлийг илрүүлэх, хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө	Жил болгоны төсөвт тусган хэрэгжүүлж байх				Компаний захирал, холбогдох мэргэжилтэн	

	боловсруулж, төслийн үйл ажиллагаа, цаг үеийн байдалтай уялдуулан тодотгол хийж байх						
2	Байгаль орчин, аюулгүй ажиллагааны хяналтыг тогтмол тавьж хэвших, ажилтан албан хаагчдад энэ чиглэлийн мэдээллийг байнга өгч байх	Тогтмол хэрэгжүүлэх				Хариуцсан мэргэжилтэн, инженер	
3	Байгаль хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах талаар жилд бүр сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Жил бүр зохион байгуулах				Төсөл хэрэгжүүлэгч, ХХАББО-ны асуудал хариуцсан мэргэжилтэн, инженер болон холбогдох мэргэжлийн байгууллага	
	Тээвэрлэж буй химийн бодисуудыг асгарч, алдагдан орчныг бохирдуулах, улмаар хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх	Тогтмол хэрэгжүүлэх				Компаний удирдлага, холбогдох мэргэжилтэн	
	Ажиллагсдыг бодисын ажиллагааны сургалтанд хамруулах химийн аюулгүй талаарх тогтмол	Мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч, компаний дотоод зохион байгуулалтаар хэрэгжүүлэх					ХХБАБ-ын тухай хуулийн 6.1.13 дахь зүйл, ААҮНАТЗ-ын тухай хуулийн 15.6.7 дахь зүйл
	Экологийн паспорт хөтлөх						Байгаль орчныг хамгаалах тухай

						Холбогдох мэргэжилтэн	хуулийн 31.1.6 дахь зүйл
--	--	--	--	--	--	-----------------------	--------------------------

**11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

№	БОМТ, БОМТ- ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагна х хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа- ны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	Орон нутгийн байцаагч	Хэрэгжилтийг хянуулах	БОМТ	6, 11 сард			Сум, багийн Иргэдийн хурлын байранд
2	Аймгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч	Хэрэгжилтийг хянуулах	БОМТ	6, 11 сард			
3	Орон нутгийн иргэдэд тайлагнах	Тайлангийн танилцуулга	БОМТ	6, 11 сард			
4	Орон нутгийн засаг захиргаа	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	6, 11 сард			
5	Аймгийн байгаль орчны газар	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	6, 11 сард			
6	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Тайлан батлуулах	БОМТ	6, 12 сард			

